



СОНГОГЧДОД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ, САНАЛ АВАХ БАЙР БЭЛТГЭХ

www.gec.gov.mn



“Санал авах байр бэлтгэх заавар, саналын хайрцаг, бүхээгийн ХЭМЖЭЭ, загвар”

СЕХ-ны 2016 оны 15 дугаар тогтоолоор баталсан.



Санал авах байр бэлтгэх:

- Санал авах байрны байршил, хаягийг санал авах өдөр хүртэлх **14 хоногийн турш** нийтэд мэдээлнэ.
- Харъяа сум, дүүргийн Засаг дарга
 - Зааврын дагуу санал авах өдрөөс **5-аас доошгүй** хоногийн өмнө



Санал авах байр бэлтгэх:

- Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбаа
- Хаяг – хэмжээг байрнаас хамаарч тогтооно.
- Өнгө заагаагүй.

**“Монгол Улсын Ерөнхийлөгчийн
сонгуулийн ... аймаг, нийслэлийн ... сум,
дүүргийн ... дугаар хэсэг дэх санал авах
байр” ГЭХ МЭТ.**



Санал авах байранд байх зүйлс:

- ✓ Сонгогчдийн нэрийн жагсаалт;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тусгайлан тоногдсон 1-ээс доошгүй тооны санал бэлтгэх бүхээг;
- ✓ Төрийн сүлд бүхий саналын хайрцаг /санал тоолох төхөөрөмжийн/;
- ✓ Сонгогчдоос саналаа нууцаар бэлтгэхэд шаардагдах 2-оос доошгүй тооны бүхээг; /300 сонгогч тутамд нэг байхаар тооцож/;
- ✓ Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, бүхээг;



Санал авах байранд байх зүйлс:

- ✓ Сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд болон ажиглагчид үзүүлэх дэлгэц /телевизор/;
- ✓ Саналын хайрцагны хувийн дугаар бүхий лац;
- ✓ Саналын хуудсанд саналаа хэрхэн тэмдэглэх тухай заавар;
- ✓ Саналын хуудсанд санал тэмдэглэх зориулалтын үзэг;
- ✓ Ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч болон мэдээллийн технологийн даамал, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан нарын ажил үүргээ гүйцэтгэхэд хүрэлцэхүйц тооны ширээ, сандал, утас, факс, компьютер принтер;



Санал авах байранд байх зүйлс:

- ✓ Цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдоогүй хэсэгт цахилгаан үүсгүүр;
- ✓ Санал авах, санал тоолох ажиллагааг баримтжуулах видео камер;
- ✓ Ажиглагчдын ширээ, сандал;
- ✓ Саналын хуудсыг хадгалах сэйф, лацны тэмдэг.



Санал авах байр:

- Санал авах байрны дотоод зохион байгуулалт нь сонгогчдод ойлгомжтой, хялбар байхаар, санал авах үйл явц ажиглагчдад бүхэлдээ харагдауйц байхаар зохион байгуулна.
- Тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.
- Санал тэмдэглэх бүхээгт:
 - сонгогч санал тэмдэглэх заавар,
 - зориулалтын үзэг болон тавиур /ширээ/
 - Сонгогчийн гар утсыг түр хадгалах хайрцаг, сав



Санал авах байранд ХОРИГЛОНО:

- ✗ нам, эвсэл, хамтарсан намуудын сонгуулийн штаб, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч байрлах;
- ✗ ухуулга сурталчилгааны байр ажиллуулах;
- ✗ нэр дэвшигчийн уулзалт, хурал, цуглаан хийх;
- ✗ нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн, эсвэл түүнийг эсэргүүцсэн сурталчилгаа явуулах.



Санал авах байранд ХОРИГЛОНО:

- ✗ Санал авах өдөр нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд байх.
 - Энэ заалт нь тэднийг саналаа өгөхөд хамаарахгүй.
- ✗ Сонгогч саналаа тэмдэглэхдээ гар утас болон зураг авах, дүрс бичлэг хийх зориулалт бүхий бүх төрлийн техник хэрэгсэл хэрэглэх.



Санал авах байрны аюулгүй байдал:

- Саналын хуудас хүлээн авснаас хойш цагдаагийн хамгаалалтад авна.
- Сонгуулийн хороод, тухайн шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, онцгой байдлын алба хариуцан гал, усны зэрэг гэнэтийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.
- Галын хор болон түүнийг хэрэглэх заавар байна.



Санал авах байр бэлтгэх

- Санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгөх бөгөөд уг асуудлыг тухайн сум, дүүргийн Засаг дарга хариуцана.



Сонгогчдод мэдээлэл хүргэх

- Санал авах байр санал авах өдрөөс арав хоногийн өмнө тухайн хэсэг дэх санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны дэвсгэр зураг /план/-ийг нийтэд зарлан мэдээлнэ.
- Нэг барилга байгууламж, цогцолборт хэд хэдэн санал авах байр байрлаж болно.



Сонгогчдод мэдээлэл хүргэх

- Аймаг, дүүргийн сонгуулийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө буюу 2017.06.06-аас өмнө санал авах байранд хүргүүлэх ажлыг зохион байгуулна.
- Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага болох санал авах байр нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны Засаг даргын тамгын газрын байранд, санал авах байр бэлэн болсны дараа санал авах байранд ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.
- Санал авах байрын албан ажлын хэрэгцээнээс бусад тохиолдолд сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулах, тараахыг хориглоно.



Санал авах газар, хугацаа

- Сонгогч Санал авах байранд биечлэн саналаа өгнө.
 - **6.26**-ны өдөр
 - Улаанбаатарын цагаар **07-22** цагийн хооронд



www.gec.gov.mn